



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/183/СТА-ТШЗ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2018 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ М.БЯМБАСҮРЭН ТАНАА

2018.02.23 № 06/528
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

01 **ЗӨРЧИЛГҮЙ**
САНАЛ ДҮГНЭЛТ

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ 020752


Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



Аудитын код: САГ-2018/183/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн аудитор Ж.Үхэртар
Утас: 99117097 Цахим хаяг: jukhertar@yahoo.com

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**


Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	4
2.9.1	Төсвийн орлого бүрдүүлэлт, төлөвлөлтийн талаар.....	4
2.9.2	Санхүүгийн програмын талаар.....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	5
3	Менежментийн захидал	6
3.1	Төсвийн орлого бүрдүүлэлт, төлөвлөлтийн талаар.....	7
3.2	Санхүүгийн програмын талаар	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн Монгол улсын Ерөнхий аудитор болон Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, “Нью эстимэйтор аудит” ХХК-ийн захирал нарын баталсан УАГ/АА2018/-140 дүгээр “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захиралтай тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Тухайн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 01-нээс 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр

төлөвлөн “Нью Эстимэйтор Аудит” ХХК-ийн аудитор Ж.Үхэртар, аудиторын туслах Ү.Алтанзул нар гүйцэтгэв.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь Дархан ургамал газар тариалан сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгээс салбарлан, салбар хүрээлэн болон үйл ажиллагаа явуулж байгаад Монгол улсын Засгийн газрын 27/78 дугаар тогтоол болон БСШУСайдын тушаалаар 2015 онд үндэсний бие даасан хүрээлэн болж өргөжжээ.

Ургамал хамгааллын тухай хууль болон БСШУСайдын 2015 оны А/337 тоот “Үйл ажиллагааны чиглэл тогтоох тухай” тушаалаар батлагдсан эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд ургамал хамгааллын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх замаар шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, тухайн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор үйл ажиллагаа явуулж байна. Тус хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын зүйлийн тархалт, хор хөнөөлийг тогтоох, тэдгээрийн био-экологийн онцлогийг судлах, байгаль орчинд халгүй тэмцэх арга боловсруулахад чиглэдэг байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсролын тухай хууль, Инновацийн тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль, Засгийн газрын тогтоол, салбарын Сайдын гаргасан тушаал шийдвэр болон бусад нийтлэг заавар, журмуудыг мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.


Тус хүрээлэнгийн бодлого хэрэгжүүлж байгаа тэргүүлэх чиглэл, цөм технологи, гаргах инновацийн бүтээгдэхүүн зэргийг үндэслэн Захирлын 2017 оны 01 дүгээр тушаалаар Захиргаа аж ахуй болон Эрдэм шинжилгээ гэсэн бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хууль, бусад хууль, тогтоол, заавар, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоол, заавар, журмыг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/



Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горимыг гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд БСШУСС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн програмтай нийцсэн байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Acolous програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь дотоод хяналтын ажлыг хариуцуулсан нэгжгүй байгаа бөгөөд тайлант онд хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь 2017 онд улсын төсвөөс 647,652.4 мянган төгрөгийн урсгал санхүүжилт, 290,017.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт тус тус авсан байна. Нэмэлт санхүүжилтийг тодруулбал бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвөөс хуваарилсан буюу ХХААХҮЯ-аас 266,567.7 мянган төгрөг, Афаси ОУБ-аас 23,450.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан байна.


Дээрх санхүүжилтээс үндсэн болон нэмэгдэл цалинд 446,824.9 мянган төгрөг, НДШ, ЭМДШ-д 51,896.2 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 326,159.3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Өмч хөрөнгийн талаар авч үзэхэд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь 2017 оны батлагдсан төсвийн хүрээнд 11,401.3 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 246.6 мянган төгрөгийн ном, нэмэлт санхүүжилтээс 40,000.0 мянган төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдан авчирч байна.

Бараа материалын хувьд 2017 онд бичиг хэргийн материал 24,126.2 мянган төгрөг, аж ахуйн материал 136,346.9 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 13,660.2 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн ба тус онд бичиг хэргийн 16,289.2 мянган төгрөг, аж ахуйн 134,453.6 мянган төгрөгийн материалыг тус тус зарцуулж ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Тус хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг www.shilendans.gov.mn/org/1135 холбоосоор оруулсан ба Үүнд: Төсөв гүйцэтгэл,



хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад мэдээллийг бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр, тухай бүр гэсэн ангиллын дагуу бүрэн мэдээлжээ.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлэхийн тулд аудит хийх төлөвлөлтийн явцад 3 эрсдэл, 11 горим, 8 сорил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлийн шатанд бүрэн хийж гүйцэтгэсэн.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Төсвийн орлого бүрдүүлэлт, төлөвлөлтийн талаар

Тус хүрээлэн нь 2017 онд төсвийн төлөвлөгөөгөөр үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3,150.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй боловч орлого оруулаагүй, төлөвлөгөө биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг зөрчиж байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.9.2 Санхүүгийн програмын талаар

Тус хүрээлэн нягтлан бодох бүртгэлдээ “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн “Acolous” програмыг ашигладаг бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн өөрчлөлтийг тусгасан програмын хөгжүүлэлт хийгээгүйгээс зарим бүртгэл, мэдээ тайланг Excel програмаар гаргадаг байна.

Шийдвэрлэсэн нь: Програмын гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж холбогдох хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийг тусгасан програмын хөгжүүлэлтийг хийлгэх талаар зөвлөмж өгөх;

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Санхүүгийн програмын талаар: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа “Acolous” програмд шинэчлэл хийх, няравын програм суулгах зэрэг нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хэрэгжилтийг нарийвчлан үзэж судлах.


Үндсэн хөрөнгийн талаар: Хуриитлагдсан зээлдээрээ анхны орлогоо нөхсөн 47,003.3 мянган төгрөгийн үнэ бүхий авто тээврийн хэрэгслийн дахин үнэлгээг хийх асуудлыг авч үзэх.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Тус хүрээлэн нь 2017 онд төсвийн төлөвлөгөөгөөр үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3,150.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй боловч орлого оруулаагүй, төлөвлөгөө биелүүлээгүй байна.



Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” програмыг ашиглаж байгаа боловч түүнд програмын шинэчлэл хийгдээгүй, няравын програм суугдаагүй байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайланд “Сенораудит” ХХК аудит хийсэн ба зарим зардлын хэтрэлттэй холбоотойгоор төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Материаллаг байдлын суурийг тооцохдоо ТАБ-СТА-А-4 маягтын дагуу нийт зардлыг суурь үзүүлэлт болгон тооцсон ба 944,746.7 мянган төгрөгийн зардлын 2 хувиар буюу 18,894.93 мянган төгрөгөөр тогтоон аудитын горимуудыг гүйцэтгэхэд материаллаг хэмжээний зөрчил гараагүй болно.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.


Энэ нь Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Төсвийн орлого бүрдүүлэлт, төлөвлөлтийн ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

2017 онд төсвийн төлөвлөгөөгөөр үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3,150.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй боловч орлого оруулаагүй, төлөвлөгөө биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Байгууллагын орлогын төлөвлөлтийг хийхдээ бодит байдал дээр үндэслэсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Орлогын төлөвлөгөө биелүүлээгүй дүнгээр үйл ажиллагааны зардлын төсөв дутагдах нөхцөл үүснэ;

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Төсвийн захирагчийн хариу

3.2 САНХҮҮГИЙН ПРОГРАМЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нягтлан бодох бүртгэлийн Acolous програмыг ашигладаг бөгөөд програмдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн өөрчлөлтийг тусгасан програмын хөгжүүлэлт хийгээгүйгээс зарим бүртгэл, мэдээ тайланг Excel програмаар гаргадаг байна.

ҮАГ-ын зөвлөмж

Програмын гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж холбогдох хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийг тусгуулах, няравын програмыг суулгуулж анхан шатны баримтын бүрдүүлэлт, бүртгэл хөтлөлт, тооцооллыг сайжруулах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Програм хангамжийг бүрэн ашиглахгүй байх нь тооцооллын механик алдаа гаргах, цаг хугацаа алдах эрсдэлтэй.


Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАА ДҮГНЭЛТ**

Төсвийн захирагчийн хариу



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл


4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,866,530.22	246,099,814.22
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	400.00	0.00
Кассанд байгаа бэлэн мөнгө	400.00	0.00
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөг/	0.00	0.00
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	0.00	131,843,200.00
Урьдчилж гарсан зардал	0.00	131,843,200.00
БАРАА МАТЕРИАЛ	90,866,130.22	114,256,614.22
Хангамжийн материал	90,866,130.22	114,256,614.22
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	616,504,083.03	560,542,710.61
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	616,504,083.03	560,542,710.61
Биет хөрөнгө	615,888,082.99	560,080,710.53
Барилга, байгууламж	32,020,000.00	32,020,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(14,609,055.60)	(16,378,777.80)
Авто тээврийн хэрэгсэл	47,003,287.69	47,003,287.69
Хуримтлагдсан элэгдэл	(42,603,287.73)	(47,003,287.69)
Машин, тоног төхөөрөмж	772,154,424.53	823,555,724.53
Хуримтлагдсан элэгдэл	(204,958,929.69)	(301,299,030.38)
Тавилга, аж ахуйн эд хогшил	121,550,472.33	121,550,472.33
Хуримтлагдсан элэгдэл	(96,773,465.78)	(101,718,895.39)
Номын фонд	2,104,637.24	2,351,217.24
Биет бус хөрөнгө	616,000.04	462,000.08
Программ хангамж	1,770,000.00	1,770,000.00
Хасалдуулга	(1,153,999.96)	(1,307,999.92)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	707,370,613.25	806,642,524.83
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
Өглөг	0.00	0.00
Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	0.00	0.00
Засгийн газрын оруулсан капитал	0.00	0.00
Хуримтлагдсан үр дүн	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00
Дахин үнэлгээний зөрүү	0.00	0.00
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	0.00	0.00
Нийт дүн	707,370,613.25	806,642,524.83

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАТ ДҮГНЭЛТ



4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	943,613,402.30	937,670,055.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	943,613,402.30	937,670,055.00
Улсын төвлөрсөн төсвөөс	732,080,000.00	647,652,400.00
Урсгал	732,080,000.00	647,652,400.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	211,533,402.30	290,017,655.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан доод	40,755,000.00	266,567,655.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс		23,450,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны дагуу	170,778,402.30	
Төсвийн захирагчдаас	0.00	0.00
Хөрөнгийн		
Татварын бус орлого	0.00	0.00
Төсөвт байгууллагын орлого	0.00	0.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	0.00
Хөрөнгийн орлого	0.00	0.00
Хандив тусламж /гадаад/		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	742,131,769.83	838,398,143.42
УРСГАЛ ЗАРДАЛ	742,658,591.83	838,398,143.42
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,131,769.83	824,880,402.42
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	533,002,417.00	498,721,066.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	479,754,351.00	446,824,866.00
Үндсэн цалин	441,336,351.00	375,616,866.00
Нэмэгдэл цалин	24,558,000.00	54,742,800.00
Унаа хоолны хөнгөлөлт	13,860,000.00	16,465,200.00
Гэрээт цалин		
Нийгмийн хамгааллын шимтгэл	53,248,066.00	51,896,200.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	53,248,066.00	48,121,930.89
Тэтгэврийн даатгалын шимтгэл	53,248,066.00	33,024,854.54
Тэтгэмжийн даатгалын шимтгэл		4,717,836.35
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		9,435,672.72
Ажилгүйдэлийн даатгалын шимтгэл		943,567.28
Эрүүл мэндийн даатгалын хураамж		3,774,269.11
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	209,129,352.83	326,159,336.42
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	209,129,352.83	326,159,336.42
Бусад бараа үйлчилгээний зардал	209,129,352.83	326,159,336.42
Гэрэл цахилгаан	166,880.00	606,961.00
Бичиг хэргийн материал	165,700.00	8,072,000.00
Гэвэр, шатахуун	1,991,600.00	1,200,000.00
Шуудан, харилцаа холбоо	1,522,790.00	1,585,827.00
Ном хэвлэл	333,000.00	7,059,800.00
Хог хаягдал устгах цэвэрлэх	170,000.00	170,000.00
Дотоод албан томилолт	56,371,896.00	85,960,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		400,000.00

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		14,900,000.00
Урсгал засвар	371,600.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	106,698,645.00	96,628,630.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох		1,000,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	211,200.00	246,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	163,170.00	160,570.00
Тээврийн хэрэгслийн даатгал	71,280.00	71,280.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	22,000.00
Газрын төлбөр	616,010.00	466,616.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,769,660.83	107,609,252.42
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	526,822.00	13,517,741.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	525,421.00	13,500,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,401.00	17,741.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)	201,481,632.47	99,271,911.58
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
Гадаад ваютын ханшийн зөрүүгийн олз / бодит/		
Үндсэн хөрөнгө худалдсаны олз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Гадаад ваютын ханшийн зөрүүгийн гарз / бодит/		
Бараа материал акталсан		
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	201,481,632.47	99,271,911.58

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**




4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	240,151,898.93	13,518,156.31	208,185,484.15	707,370,613.25
НББ-ийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			240,897,859.50	0.00
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	240,151,898.93	13,518,156.31	453,700,558.01	707,370,613.25
НББ-ийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл /дээд газраас/				0.00
Өмнөх үеийн үр дүн				0.00
Тайлант үеийн үр дүн			99,271,911.58	99,271,911.58
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	240,151,898.93	13,518,156.31	552,972,469.59	806,642,524.83



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	943,613,402.30	944,746,748.00
Улсын төвлөрсөн төсвөөс	732,080,000.00	654,729,093.00
Урсгал	732,080,000.00	647,652,400.00
Нийгмийн даатгалын сангаас	0.00	7,076,693.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	211,533,402.30	290,017,655.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгасан доод	40,755,000.00	266,567,655.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс		23,450,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны дагуу	170,778,402.30	
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		2,283,929.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	943,613,402.30	947,030,677.00
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	533,002,417.00	505,797,759.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	479,754,351.00	453,901,559.00
Үндсэн цалин	433,652,751.00	382,693,559.00
Унаа, хоолны хөнгөлөлт	16,632,000.00	16,465,200.00
Нэмэгдэл	29,469,600.00	54,742,800.00
Гэрээт цалин	0.00	0.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	53,248,066.00	51,896,200.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	53,248,066.00	33,024,854.54
Тэтгэмжийн даатгалын шимтгэл		4,717,836.35
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл		9,435,672.72
Ажилгүйдэлийн даатгалын шимтгэл		943,567.28
Эрүүл мэндийн даатгалын хураамж		3,774,269.11
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	358,738,214.00	376,067,697.00
Бусад бараа үйлчилгээний зардал	358,738,214.00	376,067,697.00
Гэрэл цахилгаан	661,801.00	606,961.00
Бичиг хэрэг	5,547,000.00	10,064,000.00
Тээвэр, шатахуун	1,991,600.00	1,200,000.00
Шуудан, харилцаа холбоо	1,522,790.00	1,585,827.00
БҮТЭЭ		
Ном хэвлэл	534,400.00	11,149,800.00
Хог хаягдал	170,000.00	170,000.00
Дотоод албан томилолт		85,960,000.00
Гадаад албан томилолт		
Нормын хувцас, зөөлөн эдлэл		550,000.00
Багаж техник хэрэгсэл		
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	17,200,000.00
Урсгал засвар	17,748,270.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	254,318,088.00	243,330,314.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,000,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	211,200.00	246,400.00
Тээврийн хэрэгслийн татвар	163,170.00	160,570.00

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Тээврийн хэрэгслийн даатгал	71,280.00	71,280.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	22,000.00
Газрын төлбөр	616,010.00	466,616.00
Бусад бараа үйлчилгээний зардал	17,500,000.00	2,283,929.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	527,281.30	13,500,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	527,281.30	13,500,000.00
ТАТААС ШИЛЖҮҮЛЭГ		17,741.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,401.00	17,741.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	892,267,912.30	895,383,197.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3=1-2)	51,345,490.00	51,647,480.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
Хөрөнгийн орлого		
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого / Үндсэн хөрөнгө авахад олгосон санхүүжилт/		
Бусад хөрөнгийн борлуулалтын орлого		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	52,345,890.00	51,647,880.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	52,345,890.00	51,647,880.00
Хөрөнгийн бусад зардал		
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (5)	52,345,890.00	51,647,880.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6=4-5)	0.00	0.00
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Авсан зээл		
Төлсөн зээл		
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (8)	0.00	0.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (9=7+8)	-1,000,400.00	-400.00
Мөнгө ба түүтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000,400.00	400.00
Мөнгө ба түүтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<i>Эхний үлдэгдэл</i>		400,00
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	650,802,400.00	647,635,114.00
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	650,802,400.00	647,635,114.00
III	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	650,802,400.00	647,635,114.00
	Бараа, үйлчилгээний зардал	637,302,400.00	634,135,114.00
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	447,453,200.00	446,824,866.00
	<i>Үндсэн цалин</i>	376,245,200.00	375,616,866.00
	<i>Нэмэгдэл</i>	54,742,800.00	54,742,800.00
	<i>Унаа болон бусад нэмэгдэл</i>	16,465,200.00	16,465,200.00
	Нийгтийн хамгаалалын шимтгэл	51,896,200.00	51,896,200.00
	Тэтгэврийн даатгал	33,024,854.54	33,024,854.54
	Тэтгэмжийн даатгал	4,717,836.35	4,717,836.35
	ҮОМШ өвчний даатгал	9,435,672.72	9,435,672.72
	Ажилгүйдлийн даатгал	943,567.28	943,567.28
	Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	3,774,269.11	3,774,269.11
	Бараа, үйлчилгээний урсгал зардал	137,953,000.00	135,414,048.00
	Гэрэл цахилгааны зардал	696,000.00	606,961.00
	Бичиг хэргийн материал	300,000.00	298,000.00
	Тээвэр, шатахууны зардал	1,200,000.00	1,200,000.00
	Шуудан холбооны зардал	1,560,000.00	1,585,827.00
	Догоод томилолтын зардал	5,500,000.00	5,500,000.00
	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	2,500,000.00	1,000,000.00
	Ном, хэвлэлийн зардал	400,000.00	228,600.00
	Нормын хувцас зөөлөн эдлэл	550,000.00	550,000.00
	Хог хаягдал устгах, цэвэрлэх	170,000.00	170,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	124,057,500.00	123,307,794.00
	Мэдээлэл технологийн зардал	246,400.00	246,400.00
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
	Тээврийн хэрэгслийн татвар	163,200.00	160,570.00
	Даатгалын үйлчилгээ	71,300.00	71,280.00
	тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
	Газрын төлбөр	516,600.00	466,616.00
	Буцаан төвлөрүүлсэн /2017 оны эцсийн үлдэгдэл/		
	Тагаас ба урсгал шилжүүлэг	13,500,000.00	13,500,000.00
	Өрх гэрт олгох шилжүүлэг	13,500,000.00	13,500,000.00
	Нийгмийн халамжийн	13,500,000.00	13,500,000.00
	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		
	Нэг удаагийн тэтгэмж	13,500,000.00	13,500,000.00
IV	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

	Хөрөнгө оруулалтын зардал	-	-
ҮИ	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	650,802,400.00	647,634,714.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,150,000.00	
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
	Бусад орлого		
	Дээд шатнаас олгосон		
	Төсвөөс санхүүжих	647,652,400.00	647,634,714.00
	Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**



АУДИТ ХИЙГДСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитлагдсан	
	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	290017,600.00
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	290017,600.00
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	290017,600.00
Бараа, үйлчилгээний зардал	-	290017,600.00
Хангамж, бараа материалын зардал	-	20771,200.00
Бичиг хэрэг	-	9766,000.00
Ном хэвлэл авах	-	11005,200.00
Эд хогшил худалдан авах	-	17200,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	17200,000.00
Томилолт, зочны зардал	-	80460,000.00
Дотоод албан томилолт	-	80460,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	171586,400.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	171586,400.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	
Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	
Төвлөрүүлэн шилжүүлэг	-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	290017,600.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	23450,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	-	266567,600.00
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Батлагдсан төлөвлөгөө
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	290,017,655.00
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	-	290,017,655.00
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	290,017,655.00
Бараа, үйлчилгээний зардал	-	290,017,600.00
Хангамж, бараа материалын зардал	-	20,771,200.00
Бичиг хэрэг	-	9,766,000.00
Ном хэвлэл авах	-	11,005,200.00
Эд хогшил худалдан авах	-	17,200,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	17,200,000.00
Томилолт, зочны зардал	-	80,460,000.00
Дотоод албан томилолт	-	80,460,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	171,586,400.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	171,586,400.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	55.00
Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	55.00
Төвлөрүүлэн шилжүүлэг	-	55.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	290,017,655.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, гусламж	-	23,450,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	266,567,655.00
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**